



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/143

Хархорин сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага
худалдаа зохион байгуулах тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмшүүлэх дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлалыг шинэчлэн батлах тухай” тушаал, Засгийн газрын 2024 оны 136 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх дуудлага худалдааны журмаар эзэмшүүлэх газрын анхны үнэ, хэмжээ, байршил, зориулалтыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад заагдсан 7 нэгж талбарыг газрын биржийн программ хангамжаар нийтэд зарлан цахим хэлбэрээр 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 09 цагт товлож, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг газрын даамал (Ч.Баттулга),(Э.Дэнсмаа) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100035

Хархорин сумын Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын 23 ны өдрийн 19/143
дугаар захирамжийн хавсралт

Дуудлага худалдааны журмаар эзэмшүүлэх газрын анхны үнэ, хэмжээ, байршил, зориулалт

д/д	Багийн нэр	Байршил	Зориулалт	Газрын хэмжээ /м2/	Дуудлага худалдааны анхны үнэ/	Дэнчин / төгрөг /
1	Ганган орхон	Соёмбо хороолол Боломж худалдааны төвийн баруун талд	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	4600	12880000	1288000
2	Ганган орхон	Соёмбо хороолол Ойдов цогцолборын баруун талд	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	3610	10108000	1010800
3	Ганган орхон	Орхон хороолол Сум дундын шүүхийн урд	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	1045	2926000	292600
4	Эрдэнэтолгой	Усжуулах 1-1 тоотын урд	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	5600	15680000	1568000
5	Ганган орхон	Соёмбо хороолол Номын хүрдэн сургуулийн урд	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	6301	17642800	1764280
6	Ганган орхон	Эрдэнэзуу гудамж 79 тоотын зүүн, Онцгой байдлын хэлтэсийн урд	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	650	1820000	182000
7	Шанх баг	Шанх багийн төвд	Барилгын материалын үйлдвэрлэл	10000	20000000	2000000
ДҮН				31806		